



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/770

Булган сум

┌ Сургалт зохион байгуулахад ┐
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны И/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1.2, 4.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ес зүйтэй, мэдлэг чадвартай, хариуцлагатай төрийн алба” сарын аяны хүрээнд зохион байгуулах төрийн албан хаагчдын ёс зүй, гэр бүл, хүүхэд хамгааллын асуудал, хувь хүний хөгжил сэдэвт сургалтуудыг зохион байгуулан удирдамжийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх ажлын гүйцэтгэгч Монголын үг урлаачдын нийгэмлэгийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Г.Бандицэрэн)-тай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

3.Сургалтыг зохион байгуулахад шаардагдах 500.000 (таван зуун мянга) төгрөгийг Сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарт, 18,000,000 (арван найман сая) төгрөгийг “Шинэ Ирээдүй” хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн 11 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

“ЁС ЗҮЙТЭЙ, МЭДЛЭГ ЧАДВАРТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА” САРЫН АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

НЭГ.ЗОРИЛГО

Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, Төрийн албаны шинэтгэлийг орон нутгийн түвшинд эрчимжүүлэх, төр иргэдийн хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

ХОЁР.ХУГАЦАА

2023 оны 11-р сарын 13-ний өдрөөс 11-р сарын 30-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулагдана.

ГУРАВ.ХАМРАХ ХҮРЭЭ

Булган аймагт ажиллаж амьдарч буй төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, төрийн тусгай албан хаагчид, Иргэд, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, Мэргэжлийн сургалтын боловсролын байгууллагын суралцагчид хамрагдана.

ДӨРӨВ.ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Булган аймгийн Засаг даргын тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, шинжлэх ухааны газар, Монголын үг урлаачдын нийгэмлэгийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, сэтгэл зүйч, лектор Г.Бандицэрэн

ТАВ.СУРГАЛТЫН ЧИГЛЭЛ

- Төрийн албан хаагчдын ёс зүй
- Гэр бүл, хүүхэд хамгааллын асуудал
- Хувь хүний хөгжил

ЗУРГАА.СУРГАЛТЫН ХУВААРЬ

| № | Сумын нэр | Хуваарьт өдөр | Хариуцах |
|---|-----------|--------------------------------|------------|
| 1 | Бугат | 11-р сарын 13 | Сумын ЗДТГ |
| 2 | Хялганат | 11-р сарын 14 | Сумын ЗДТГ |
| 3 | Сэлэнгэ | 11-р сарын 15 | Сумын ЗДТГ |
| 4 | Хангал | 11-р сарын 16 | Сумын ЗДТГ |
| 5 | Булган | 11-р сарын 17 11-р сарын 18 | Сумын ЗДТГ |
| 6 | Сайхан | 11-р сарын 20 | Сумын ЗДТГ |
| 7 | Баян-Агт | 11-р сарын 21 | Сумын ЗДТГ |

| | | | |
|----|-------------|---------------|------------|
| 8 | Хутаг-Өндөр | 11-р сарын 22 | Сумын ЗДТГ |
| 9 | Тэшиг | 11-р сарын 23 | Сумын ЗДТГ |
| 10 | Бүрэгхангай | 11-р сарын 24 | Сумын ЗДТГ |
| 11 | Дашинчилэн | 11-р сарын 25 | Сумын ЗДТГ |
| 12 | Рашаант | 11-р сарын 26 | Сумын ЗДТГ |
| 13 | Гурванбулаг | 11-р сарын 27 | Сумын ЗДТГ |
| 14 | Хишиг-Өндөр | 11-р сарын 28 | Сумын ЗДТГ |
| 15 | Орхон | 11-р сарын 29 | Сумын ЗДТГ |
| 16 | Могод | 11-р сарын 30 | Сумын ЗДТГ |

6.2. Булган сумын зохион байгуулалтын хуваарь

| № | Байгууллагуудын нэрс | Хугацаа | Байршил | Хариуцах |
|-------------------------------|---|--|--------------------------------------|---------------------------|
| 2023 оны 11-р сарын 17 | | | | |
| 1 | АИТХ, АЗДТГ, Санхүү Аудит, Байгууллагын дарга нар | 2023.11.17-ны өдөр (08:00-10:00) цагт | АЗДТГ 107 тоот | АЗДТГ, ТЗУХ |
| 2 | Төрийн байгууллагын албан хаагчид | 2023.11.17-ны өдөр (10:30-12:30) минут | Булган аймгийн Хөгжимт жүжгийн театр | АЗДТГ, ТЗУХ |
| 3 | Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль | 2023.11.17-ны өдөр (14:00-15:30) минут | 1 сургуулийн урлаг заал | БШУГ, Сургуулийн захиргаа |
| 4 | Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль | 2023.11.17-ны өдөр (16:00-17:30) цагт | 2-р сургуулийн урлаг заал | БШУГ, Сургуулийн захиргаа |
| 2023 оны 11-р сарын 18 | | | | |
| 1 | Боловсролын салбарын албан хаагчид | 2023.11.18-ны өдөр (10:00-12:00) цагт | Булган аймгийн Хөгжимт жүжгийн театр | НБХ, БШУГ |
| 2 | Эрүүл мэндийн салбарын албан хаагчид | 2023.11.18-ны өдөр (12:30-14:30) | Булган аймгийн Хөгжимт жүжгийн театр | НБХ, ЭМГ |
| 3 | Хууль, эрх зүйн салбарын албан хаагчид | 2023.11.18-ны өдөр (15:00-17:00) | Булган аймгийн Хөгжимт жүжгийн театр | ХЭЗХ, Цэргийн штаб |
| 4 | Булган аймгийн Иргэд | 2023.11.18-ны өдөр (17:30-19:30) цагт | Булган аймгийн Хөгжимт жүжгийн театр | Булган СЗДТГ |
| 2023 оны 11-р сарын 19 | | | | |
| 1 | Ерөнхий боловсролын 3 сургууль | 2023.11.19-ны өдөр (11:00-12:30) минут | 3 сургуулийн урлаг заал | БШУГ, Сургуулийн захиргаа |

| | | | | |
|---|-------------|---|-----------------|---------------------------------|
| 2 | Булган МСҮТ | 2023.11.19-ны өдөр (13:00-14:30) минут | Сургуулийн заал | БШУГ, Сургуулийн захиргаа |
| 3 | ХАА-н МСҮТ | 2023.11.19-ны өдөр (15:30-17:00) цаг | Сургуулийн заал | БШУГ, Сургуулийн захиргаа |

Аймгийн Засаг даргын 2023 оны 11
дугаар сарын 15-ны өдрийн 1719 Дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**“ЁС ЗҮЙТЭЙ, МЭДЛЭГ ЧАДВАРТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА” САРЫН АЯНЫ
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ТӨСӨВ**

| № | Шаардлагатай зардал | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Үнэ /төгрөг/ | |
|-------------|-----------------------------------|-------------|------------|--------------|-------------------|
| | | | | Нэг бүр | Нийт |
| 1 | Сургагч багшийн цалин (Гэрээгээр) | тоо | 16 | 1.500.000 | 24.000.000 |
| 2 | Шатахуун АИ92 (15 сум, 1 тосгон) | литр | 793.6 | 2520 | 2.000.000 |
| НИЙТ | | | | | 26.000.000 |